

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНД АНХААРАХ АСУУДАЛ

### POLICE TRAINING SYSTEM, ISSUES TO BE CONCERNED

**О.УУЛЗАХЖАРГАЛ**

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний туслах ажилтан, хууль зүйн магистр

**UULZAKHJARGAL O.**

Assistant Researcher at the Police Studies Center, Research and  
Development Institute, Law Enforcement University, Master of Law

**Товч агуулга:** Цагдаагийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ойртуулах, тэдний оролцоог идэвхжүүлж нийгмийн шинэ нөхцөл байдал, шаардлагад нийцүүлж, менежментээ боловсронгуй болгож, цагдаагийн алба хаагчийнхаа мэдлэг чадварыг сайжруулан олон улсын цагдаагийн байгууллагын дэвшилтэй арга барилд суралцах явдал чухлаар тавигдаж байна. Энэ цаг үед цагдаагийн мэргэшүүлэх сургалтын эрх зүйн орчин, арга хэлбэрийг боловсронгуй болгох, чанар үр нөлөөг шинэ шатанд гаргах гарцыг эрэлхийлэхийг зорьж энэхүү илтгэлийг бичжээ.

**Abstract:** It is important to develop and enhance police service to be closer to the public, strength their activities in the modern society, improve their knowledge and make them internationally competitive. The purpose of the article is to concern immediate step for police training legal environment the efficiency of training.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг мэдлэг чадвартай, хүнлэг албан хаагчдын хүчээр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь иргэдтэй ажилладаг тэднийг иргэнийх нь хувьд ч тэр, төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчийн хувьд ч тэр, мэргэжлийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх шаардлагатай бөгөөд тэгэхдээ сургалт нь хувь хүнд чиглэсэн, тэднийг хөгжүүлэх, боловсрол олгох хэрэгцээ урган гарч байна.

Хүний нөөцийн хөгжил бол байгууллагын амжилттай үйл ажиллагааны нэг чухал хүчин зүйл юм. Иймд хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь бусад нөөцөд хөрөнгө оруулалт хийснээс илүү их үр ашигтай байдаг. Учир нь хүнийг хөгжүүлж чадвал жил ирэх тутам үнэ цэнэ нь өсөж, боловсорч хөгжихийн хэрээр сэтгэж, сэтгэхийнхээ хэрээр бүтээгээд байдаг онцлогтойгоороо бусад нөөцүүдээс давуу талтай байдаг явдал юм.<sup>1</sup>

**Байгууллагын сургалт нь** ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, мэргэшлийн бэлтгэл, ур чадвар, туршлага дутагдаж буй үед ажилтныг тусгай бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу сургах үйл явц юм.<sup>2</sup>

Сургалтын үр дүнд байгууллагад өндөр бүтээмж, чанар бий болж, ингэснээр байгууллагын өрсөлдөх чадвар нэмэгддэг. Мөн ажилтнууд сургалтад тасралтгүй хамрагдсанаараа ажлын шинэ арга, технологийг амархан эзэмших чадвартай болж, улмаар ажилдаа сэтгэл ханамжтай байснаар боловсон хүчний тогтворжилт сайжирдаг сайн талтай.

Төрийн үндсэн чиг үүргийн нэг болох нийгмийн хэв журам сахиулах, гэмт

<sup>1</sup> Б.Даваажав, “Хүний нөөц, чадавхийг хөгжүүлэн чадваржуулах” 2008.

<sup>2</sup> Ц.Цэцэгмаа, “Хүний нөөцийн менежмент” 2001. УБ., 33 дугаар хуудас

хэргээс иргэн, төр, нийгмийг хамгаалах асуудал нь түүхийн тодорхой үеүдэд улс орон бүрт харилцан адилгүй чиг үүрэг бүхий онцлог шинжтэй үйл ажиллагаа явуулдаг цагдаагийн байгууллага, түүний албан хаагчдын хүч, хэрэгслээр хамгаалагдаж байдаг.

Ийм учраас дээрх чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлэх, тэдний байнга сурч боловсрох бололцоогоор хангах, зөв сонгон шалгаруулж авах, мэргэшүүлэх, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал болон улс орны хөгжилтэй нийцүүлэн алба хаагчдыг хөгжүүлэх, сурах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүй ёсны шаардлага юм.

**Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан мэргэшүүлэх сургалтын тогтолцоо, төрөл.**

**Мэргэжлийн сургалт.** Өнөөгийн байдлаар цагдаагийн мэргэжлийн боловсон хүчнийг дотооддоо Хууль сахиулахын их сургуульд, гадаадад ОХУ, БНТУ-ын мэргэжлийн их, дээд сургууль, академид захиалгаар бэлтгэж байна.

№	Мэргэжлийн чиглэл	Сургалтын хугацаа	Эзэмших боловсролын зэрэг
<b>Нэг. Мэргэжлийн сургалт</b>			
1	Цагдаа	1 сар – 1 жил хүртэл	Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт
2	Ц а г д а а - х у у л ь сахиулагч	4-5 жил (өдөр, эчнээ)	Бакалавр
<b>Хоёр. Боловсролын зэрэг ахиулах сургалт</b>			
1	Хууль зүй	1,5- 2 жил	Магистр
2	Хууль зүй	3-5	Доктор (Ph.D)

**Алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалт.** Цагдаагийн алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалтын бодлогыг хэрэгжүүлдэг үндсэн нэгж буюу сургалтын байгууллага нь Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 2014 оны 2 дугаар сард байгуулагдсан Сургалт, дадлагын төв юм.

Алба хаагчдын мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоож, ажлын байрны тодорхойлолтод заагдсан үйл ажиллагааг хэвийн явуулахад нь шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадварыг олгох, дадлагажуулахад чиглэгдэнэ.

Сургалт, дадлагын төвийн чиг үүргийг тус төвийн дүрмийн<sup>3</sup> 1 дүгээр зүйлийн 1.4-д зааснаар “Цагдаагийн байгууллагын сургалт, хүний хөгжлийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, цагдаагийн албадын сургалт, хүний хөгжлийн ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий сургалт, дадлагын байгууллага мөн” гэжээ.

Сургалт, дадлагын төвд цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулагдах төдийгүй “Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх”, “Гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх”, “Иргэдэд зориулсан галт зэвсэг хэрэглэх арга зүйн сургалт”, “Иргэний зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт” зэрэг гадагш чиглэсэн зорилтот сургалтууд зохион байгуулагддаг.

**Сургалтын давтамж, төрөл, хэлбэр:**

Цагдаагийн алба хаагчдыг 2-3 жил тутам мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад заавал оролцуулна. Цагдаагийн алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалт дараах төрөлтэй байна.

- Давтан сургалт - Цагдаагийн алба хаагчдын нийтлэг болон албан тушаалын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварын түвшинг дээшлүүлэх зорилгоор 5-10 хоногийн хугацаанд зохион байгуулж байна.

<sup>3</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 59, 229 дүгээр тушаалаар баталсан.

- Мэргэшүүлэх сургалт - Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тодорхой чиглэлээр үүрэг гүйцэтгэх (хүний амь, бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийг илрүүлэх арга, тактик, хулгайлах гэмт хэргийг илрүүлэх арга, тактик) мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэхэд чиглүүлэн 10-21 хоногийн хугацаагаар явуулж байна.

- Зорилтот сургалт - Цагдаагийн албанд шинээр томилогдсон алба хаагчдад албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл өгөх, мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх, цагдаагийн офицер албан тушаалд томилогдон ажиллах алба хаагчийг бэлтгэх, удирдах албан тушаалтныг бэлтгэх зорилгоор зохион байгуулагддаг сургалт юм.

- Ур чадварын сургалт - Алба хаагчийг цагдаагийн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх ур чадварыг эзэмшүүлж, дадлагажуулж, чадавхжуулах зорилгоор 5-10 хоногийн хугацаагаар зохион байгуулж байна.

- Хүний хөгжлийн сургалт - Цагдаагийн алба хаагчийг хөгжүүлэх, ерөнхий мэдлэг, ур чадварын түвшинг нь дээшлүүлэх зорилгоор бусад сургалтын байгууллагууд болон төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Гадаад хэлний (орос, англи, солонгос), өөрийгөө хөгжүүлэх арга зүй эзэмшүүлэх гэх зэрэг юм.

### **Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Цагдаагийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, алба хаагчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан, олон улсын цагдаагийн байгууллагын сургалтын жишигт нийцсэн үргэлжилсэн сургалтад хамруулж мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, байнга хөгжүүлэх нь цагдаагийн байгууллагын стратеги, төлөвлөлтийн үндсэн асуудлуудын нэг юм.

Үүнийг цагдаагийн байгууллагын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд онцгойлон анхаарч цагдаагийн алба хаагчийн сургалттай холбогдох асуудлыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, даган мөрдөж буй Цагдаагийн албаны тухай хуульд тусгайлан зааж зохицуулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн Цагдаагийн албаны сургалтын байгууллага гэсэн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн бүрэлдэхүүнд цагдаагийн алба хаагч, ажилтныг бэлтгэх үүрэг бүхий сургалтын байгууллага байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан сургах, албаны сургалт явуулах сургалтын төвийг хот, орон нутагт бүсчлэн байгуулж болно” гэж тус тус заасан нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалтын байгууллагын тогтолцоог төдийгүй сургалтын зорилго, төрөл, хэлбэрийг тогтоосон хэрэг юм.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалт нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон одоо даган мөрдөж байгаа Цагдаагийн байгууллагын сургалтын бодлого хэрэгжүүлэх (код 117), Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх (код 243), Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх (код 942), Гадаадад суралцагчийг сонгон шалгаруулах, богино хугацааны сургалтад оролцуулах (код 944) журмууд мөн холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

Өнөөгийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 74 дүгээр тушаал “Цагдаагийн байгууллагын боловсон хүчний заавар”, Цагдаагийн ерөнхий

газрын даргын 2003 оны 89 дугаар тушаал “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дунд явуулах сургалт, соён гэгээрүүлэх ажлын үндсэн чиглэл”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 208 дугаар тушаал “Албаны сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцох, тайлагнах журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2004 оны 205 дугаар тушаал “Цагдаагийн байгууллагын албаны сургалт, арга зүйн кабинетын үлгэрчилсэн стандарт” болон холбогдох бусад эрхийн актыг батлан мөрдлөг болгон цагдаагийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

Одоо мөрдөгдөж байгаа дээрх эрх зүйн актуудыг харьцуулан судалж үзвэл зарим нэг эрх зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох шаардлагатай болоод байна.

“Албаны сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцох, тайлагнах журам”-д зааснаар “...ерөнхий мэдлэгийн буюу суурь боловсролын сургалт, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт гэж 2 бүлэгт хуваасан...”<sup>4</sup> ч одоогийн нөхцөл байдалтай төдийлөн уялдахгүй байна.

### **Цагдаагийн байгууллагын шинэтгэлд сургалтын тогтолцоог авч үзэх нь**

Цагдаагийн албаны болон мэргэжлийн сургалтыг боловсронгуй болгох нь цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх үндсэн нөхцөл болж байгаа тул Цагдаагийн ерөнхий газраас жил бүр сургалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, алба хаагчийн мэдлэг, чадавхийг сайжруулна гэж онцгойлон зорилт дэвшүүлдэг.

Тухайлбал,

– 2002 онд “Албаны сургалт, алба хаагчийн сахилга, ёс зүй, харьцааны соёлын түвшинд ахиц гаргах”,

– 2005 онд “Алба хаагчийн сургалтын чанар, мэдлэг чадварыг дээшлүүлж, харилцааны соёл, ёс зүйг төлөвшүүлэхэд бүх шатны дарга нарын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх”,

– 2006 онд “Бүх шатны даргалах бүрэлдэхүүний манлайллыг өндөржүүлж, сургалтын чанар, алба хаагчдын мэдлэг, ур чадвар, хариуцлага, ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх”,

– 2008 онд “Сургалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, алба хаагчийн мэдлэг, чадавхийг сайжруулах”,

– 2011 онд “Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажлын үр дүн, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх”,

– 2012 онд “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх”,

– 2013 онд “Удирдах бүрэлдэхүүний манлайлал, удирдлагын арга барил, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх” гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

*Бүх шатны удирдах ажилтан, ахлах офицеруудын үлгэрлэн манлайлах үүрэг, хариуцлагын талаар өндөр шаардлага тавьж, залуу ажилтнуудыг сурган дадлагажуулах, ажил үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ажил амьдралын зөв дадал хэвшилд сурган төлөвшүүлэх ажилд тэдгээрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх...<sup>5</sup> Шинээр болон шилжүүлэн томилсон алба хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үр бүтээлтэй ажил зохиож, ахмад*

<sup>4</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2004 оны 205 дугаар тушаал

<sup>5</sup> ЦЕГ-ын даргын 2006 оны 09 дугаар албан даалгавар

туршлагатай ажилтнуудыг дагалдуулан сургаж дадлагажуулах...<sup>6</sup> зэргээр онцгойлон анхаарч, Цагдаагийн ерөнхий газрын дарга албан даалгаврууд гарган төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн хэрэгжүүлжээ.

*Цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад албаны болон мэргэжлийн сургалт чухал байр суурь эзэлдэг билээ.*

*Өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагын хэмжээнд алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг дараах чиглэлээр явуулж байна. Үүнд:*

- Цагдаагийн анхан шатны сургалт,
- Бакалавр, магистр, докторын сургалт,
- Мэргэшүүлэх болон давтан сургалт,
- Цагдаагийн газар, хэлтэст явуулах албаны сургалт,
- Гадаад сургалт,
- Зайны сургалт гэсэн чиглэлээр явагдаж байна.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүд Цагдаагийн ерөнхий газраас жил бүр батлан хүргүүлдэг сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэжлийн сургалтаа зохион байгуулдаггүй, зохион байгуулсан ч алба хаагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлаагүй, чанар, үр дүнгүй сургалтыг зохион байгуулж байгаагаас алба хаагчдаас урьд гаргаж байсан сахилгын зөрчил, дутагдлууд давтагдан гарч, цаашид өсөх хандлагатай байна.

**Өнөөгийн сургалтын ололттой тал:** Дээр дурдсанчлан сургалтын ач тус бидэнд зайлшгүй хэрэгтэй байдгийг уламжлахын зэрэгцээ алба хаагчийг хүн гэдэг талаас нь хөгжүүлэх, мэргэжлийн талаас нь мэргэшүүлэх, ухамсар ёс суртахуунд нь нөлөөлөх зэрэг олон талт сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагын багш нар болон байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан сургагч багшийг газар, хэлтсүүдээс захиалан авч бэлтгэн тасралтгүй зохион явуулж байгаа нь ололттой тал юм.

**Дутагдалтай тал нь:** Гэсэн хэдий ч бүх зүйл нэг дор төгс бүтээл болдоггүйн адил алдаатай, доголдолтой тал бас байна. Үүнд: Сургалтын төлөвлөгөө нь бүдэг, хэт ерөнхий, алба хаагчдаас санал авахыг зорьдог боловч хүсэл, шаардлагад нь нийцэх, зайлшгүй эрэлт хэрэгцээтэй байгаа сургалтын талаарх саналыг авахдаа давчуу хугацаанд нэр төдий авдаг учир тусгагдах магадлал муутай, алба хаагчдаас үйлдэгдээд байгаа гэмт хэрэг, зөрчил, дутагдал, сахилга, ёс зүйн зөрчил зэрэг болон улсын, нийслэлийн хэмжээнд үйлдэгдээд байгаа гэмт хэрэг, зөрчил тэдгээрийн шалтгаан, нөхцлийг судалсны үндсэн дээр түүнийг арилгахад чиглэсэн нягт нарийвчлан улирал, сар, тухай бүрээр төлөвлөн төлөвлөгөөг алба хаагч нэг бүрт бүрэн мэдэгдэж, мэдснээрээ ажил үйлчилгээгээ зохицуулдаг, бэлтгэлээ хангадаг, сэдэв тухай бүрт тохирох санал, сэтгэгдлээ бэлтгэн ирж идэвх санаачлалтай хамрагдах, тэгэснээрээ аливаа сургалт уулзалтын дараа ямар нэгэн шийдвэрлэх үр дүнг үздэг болох юм бол жинхэнэ утгаараа сургалтын ач тусаар бидний хөгжил дэвшил нэмэгдэх давуу талтай юм.

Тэгээгүйгээс өдөрт төлөвлөсөн өөр ажлын дундуур гэнэтийн байдлаар сургалт оруулсны улмаас алба хаагчийн өдрийн төлөвлөгөө нурах, түүнээсээ үүдэн бухимдах, үйлчлүүлэгч иргэдэд хүлээлт үүсгэх, мөн бухимдал шүүмжлэл бий болгох, сургалтад ач холбогдол өгөхгүй тээр шаах, тэр ч бүү хэл хөмсөг зангидсан олон алба хаагчийн дунд орж ирсэн багш хүртэл эвгүй байдалд орох асуудал гардаг. Мөн зарим багшийн чадавх сул нь алба хаагчдын дунд сургалтыг цаг үрсэн, ажилд саад болсон зүйл мэтээр ташаа бодол төрүүлж, сөрөг хандлагыг бий болгодог. Жишээ нь, зарим багш заах сэдвээ гартаа оруулаагүй, орж ирэнгүүтээ компьютер

<sup>6</sup> ЦЕГ-ын даргын 2007 оны 02 дугаар албан даалгавар

хэрэгслээрээ оролдон хугацаа идэх, чин сэтгэлээсээ мэдлэг олгохыг зориогүйгээ илтэд мэдэгдүүлж, цаг бүртгэн, өөр өөрсдийн хийх шаардлагатай зүйлээ хийгээд эвтэйхэн тарцгаахыг ичихгүй сануулж нүд хуурах хэлбэрийг эрхэмлэдэг, ярих илтгэх чадваргүй, ээрч гацдаг, юу ярих гэж байгаа нь ойлгомжгүй дэс дараалалгүй эсвэл шууд цаасан дээр бичсэн зүйлийг минутын уншлага шиг уншиж дуусгадаг, дуу хоолойны өнгө нь сул эсвэл зандрангүй, заналхийлсэн хэлбэртэй, хэдэн хүнд хэдэн цагийн ямар сургалтыг ямар хэлбэрээр өгөхөө өөрөө төлөвлөдөггүй, нүүр, биеийн хөдөлгөөн, хувирал, биеэ авч яваа байдал, хувцаслалт зэрэгтээ анхаардаггүй, зэрэг нь сургалтыг үнэгүйдүүлэхэд хүргэдэг байна.

Багш нараас гаргадаг дээрх дутагдлын дийлэнхийг манай байгууллагаас дотооддоо бэлтгэсэн сургагч багш нарын зүгээс гаргадаг нь анх сургагч багшаар бэлтгэх захиалгыг хэлтэс албад руу өгөхөд нийт алба хаагч нарт мэдээлэхгүй, ямар нэгэн сонгон шалгаруулалтгүй, бас нэг түр ч атугай ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй нэр хүндийн араас хөөцөлддөг, өөрийгөө таниагүй, доор байгаа хэдэн даргын өхөөрдөм бөмбүүлэйнүүд яваад бэлтгэгдчихсэн байдаг нь нууц биш гэж хатуухан дүгнэсэн нь үнэнд ауйрхон.<sup>7</sup>

### **Тулгамдсан асуудал:**

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэгт заасны дагуу төрийн алба хаагч нь төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх баталгаагаар хангагдана гэсэн заалт бодит байдалд нийцэхгүй байна. Суралцагч нь зөвхөн өнөө маргаашийн ахуй, амьдралын хэрэгцээг хангах төдий хэрэглээний төвшний мэдлэгтэй байхдаа ч бус, мөн олон талын өргөн эсвэл тухайн нэг чиглэлийн гүнзгий мэдлэгийг эзэмшихдээ ч бус, харин хэрэгцээтэй шинэ мэдлэгээ бүтээх, хадгалах, шаардлагатай үед сэргээн хэрэглэх сэтгэлгээний хэв маяг, арга хандлага, сэтгэхүйн барил, эзэмших нь чухал юм.

“Боловсон хүчний зааварт” “...цагдааг 5 жил тутамд, дунд тушаалын алба хаагчдыг 3-5 жил тутамд мэргэжил дээшлүүлэх сургалтад, бакалавр, магистрын зэрэгтэй тодорхой үр бүтээлтэй ажиллаж байгаа алба хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад, удирдах ажилтныг мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулна...”<sup>8</sup> гэж заасан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 208 дугаар тушаал “Албаны сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцох, тайлагнах журам”-д “... албаны сургалтын агуулга, зохион байгуулалтыг ерөнхий мэдлэгийн буюу суурь боловсролын сургалт, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт...”<sup>9</sup> гэж ангилсан.

Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад алба хаагчдын эрхэлж байгаа албан тушаалынх нь чиглэлээр гүйцэтгэх ажил, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, замын цагдаа, удирдах албан тушаалтан, хэв журмын зэрэг төрөл мэргэжлийн албадын арга, тактикийг тэднээр гүнзгийрүүлэн судлуулж, албаны соёл, сэтгэл зүй, дадлага чадварыг нь төгөлдөржүүлэхийн тулд практик амьдралын явцыг мэдэрч, түүнд түшиглэсэн хичээлүүдийг явуулах, боловсролын зэрэг харгалзахгүйгээр тухайн албаны тушаалыг эрхэлж байгаа хүмүүс хамрагдана гэж нарийн заасан байна.

Дээрх заавар, журмын дагуу одоо ажиллаж байгаа цагдаагийн офицер, ахлагч нарын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх мэдлэг чадварыг хангахад алба хаагч нэг бүрийг 3-5 жилийн хугацаанд 14-30 хоногийн хугацаагаар давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах зайлшгүй шаардлагатай юм.

Тэгвэл одоо батлагдсан орон тоогоор Цагдаагийн ерөнхий газрын 2014 оны

<sup>7</sup> Ш.Бурмаа, “Цагдаагийн байгууллагын шинэтгэл, тогтолцоо” илтгэл. 2014 он

<sup>8</sup> Цагдаагийн ерөнхий газрын 2002 оны 74 дугаар тушаал

<sup>9</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 208 дугаар тушаал

9-р сарын 25-ны байдлаар 9131 орчим офицер, ахлагч ажиллаж байгаа ба алба хаагч нэг бүрийг 3-5 жилийн хугацаанд нэг удаа давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулна гэж үзвэл жил тус бүр 1875-2000 орчим алба хаагчийг сургах хэрэгцээ гарч байгаа ба нэг албан хаагчийг 14-30 хоногийн хугацаагаар сургалтад хамруулахад сургалтын хэлбэрээс хамааран сургалтын зардал, төсөв нэмэгдэх хандлагатай байна.

Энэ нь одоогийн төсөвт багтаан давтан болон мэргэшүүлэх сургалтыг явуулах нь ямар ч боломжгүй байна.

Ялангуяа хөдөө орон нутгийн алба хаагчдыг тодорхой хугацаагаар ажлын байрнаас нь хөндийрүүлэхээс гадна ирж буцах замын болон томилолтын зардал их гардаг зэргээр алба хаагч нэг бүрийг сургалтад хамруулах, тэдний мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж чадахгүйд хүрээд байна.

Түүнээс гадна төвлөрсөн сургалтуудыг улсын хэмжээнд мэргэжлийн сургалтын төвийг түшиглэн явуулж ирсэн ба сургалтад хамрагдаж буй төв, орон нутгийн албан хаагчдыг байрлуулах байр, анги танхим, багшлах бүрэлдэхүүний орон тоо, нэг багшид оногдох ажлын ачаалал, томилолтын зардал, зэргийг тооцож үзвэл өнөөгийн, мэргэжлийн сургалтын төвийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх шаардлага ч харагдаж байна.

Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2004 оны 205 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын албаны сургалт, арга зүйн кабинетын үлгэрчилсэн стандарт”-ын дагуу давтан болон мэргэшүүлэх сургалт явуулах анги, танхимгүй байхгүй, багшлах алба хаагчид бэлтгэгдээгүй зэрэг олон хүндрэл байна.

Цагдаагийн газар, хэлтсийн удирдлагууд ажлын ачаалал, бусад нөхцөл байдлаас шалтгаалан алба хаагчдаа сургалтад хамруулах сонирхол байдаггүйгээс тухайн алба хаагчдаас нь мэргэжлийн ур чадвар дутагдаж алдаа дутагдал гаргах, сахилга ёс зүйн зөрчил гаргах явдал их болсон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах, олон улсын цагдаагийн байгууллагын дэвшилттэй арга барилд суралцах явдал чухлаар тавигдаж байгаа өнөө үед өндөр хөгжилтэй бусад АНУ, БНХАУ, Солонгос зэрэг улс оронд цагдаагийн байгууллагад шаардлагатай нарийн мэргэжлийн чиглэлээр алба хаагчдыг мэргэшүүлэх боломж бололцоо бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Цагдаагийн алба хаагчид мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаа ч өөрийгөө хөгжүүлэх талаар төдийлөн анхаарал тавихгүй байна. Тухайлбал, гадаад харилцаа өргөжиж байгаа энэ үед гадаад хэлний мэдлэгтэй цагдаагийн алба хаагчид байхгүй байна. Монгол Улсад ажиллаж амьдарч байгаа иргэд, жуулчид гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад ихээр өртөх болсон энэ үед гадаадын иргэд, жуулчдад цагдаагийн үйлчилгээг ойртуулах, тэдэнд шуурхай үйлчлэх, тэдний аюулгүй орчинд аж төрөх, аялах нөхцөл бололцоог хангахад гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчид дутагдалтай байна.

Мөн цагдаагийн байгууллагаас гаргаж байгаа олон эрх зүйн актад мэргэшүүлэх сургалтын нэр томьёо өөр өөр байдлаар бичигдэж байгааг анхаарч, нэгдсэн нэг нэр томьёонд шилжих шаардлагатай нь ажиглагдаж байна.

Тухайлбал:

- Мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх,
- Мэргэшүүлэх,
- Мэргэжил дээшлүүлэх гэж тодорхойлж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай “мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөрийг эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг, “мэргэжлийн сургалт” гэж иргэнд тодорхой мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааг, “мэргэшил”

гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадварын түвшинг тодорхойлжээ.

Эдгээр тодорхойлолт нь алба хаагчдын онол болон практик мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тодорхой үйл ажиллагаанд мэргэшүүлэн сургах нэг зорилготой байдаг болохоор алба хаагчдыг мэргэшүүлэх гэдэг тодорхойлолт нь илүү амьдралд ойрхон байна.

### **Дүгнэлт, санал.**

Цагдаагийн байгууллагын давтан болон мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагаанд цогц байдлаар судалгаа хийх шаардлагатай болжээ. Өнөөдрийг хүртэл явуулж ирсэн сургалт хэрхэн үр дүнгээ өгснийг судлахаас гадна сургалтын бүтцийн элементүүдээр нь авч үзэж, далайцтай судлах шаардлагатай байна. Тухайлбал, давтан болон мэргэшүүлэх сургалтын зорилго, зохион байгуулалтын хэлбэр, стандарт, технологи, үр дүнгийн үнэлгээ, багшлах боловсон хүчин, санхүүжилт, сургалт явуулах орчин зэрэг элементээр задалж хийсэн, харьцуулсан судалгаа хэрэгтэй болж байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын давтан болон мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагааны явцыг харахад сургалтанд хамрагдагсдыг идэвхжүүлэх аргуудыг ашиглахгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Цагдаагийн ерөнхий газраас 2014-2015 онд цагдаагийн алба хаагчдыг сургаж, хөгжүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж, сургалтын үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журмуудыг шинэчлэх, нэмэлт, өөрчөлт оруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Тухайлбал, "Сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах журам", "Цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтын журам", "Алба хаагчаас мэргэшлийн түвшин тогтоох шалгалт авах журам"-ын төслийг шинээр боловсруулсан нь үр дүнтэй алхам болжээ.

Сургалт, дадлагын төвийн удирдлага, зохион байгуулалт, багшлах бүрэлдэхүүн, материаллаг орчныг сайжруулж, бэхжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэх, чадавхжуулах ажлыг бодлогын түвшинд зохион байгуулж, гадаад, дотоодод суралцуулах, сурган, заах арга зүйн мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах нь зүйтэй хэрэг.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын давтан болон мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагааны явцыг харахад сургалтанд хамрагсдыг идэвхжүүлэх аргуудыг ашиглахгүй байгаа нь учир дутагдалтай байна. Тухайлбал, сургалтын олон идэвхжүүлэлтийн аргыг ашиглахгүй байна.

Цагдаагийн байгууллагын явуулж буй сургалт нь өөрийн гэсэн онцлогтой байдаг учир идэвхжүүлэлтийн аргуудыг сонгож хэрэглэхдээ тухайн сургалтын зорилгодоо хэр нийцэж байгаа талаар сайтар бодох, хэрэглэх бүртээ боловсронгуй болгож байх зайлшгүй шаардлагатай бөгөөд хэрэглэхийн өмнө сайн бодож төлөвлөсөн байвал илүү үр дүнтэй байна.

Судалгаанд үндэслэн цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх, тасралтгүй хөгжүүлэх, тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэжил, мэргэшлийн чадамжийг нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн бэлтгэд сургахад анхаарч хүч хөрөнгө зарцуулах;
- Алба хаагч бүр суралцагч байх, өөрийгөө хөгжүүлэх идэвх санаачлагыг өрнүүлэх, удирдлагаас дэмжих;
- Хууль сахиулагчийн хэвшмэл хандлагыг өөрчлөх, мэдлэгийг шинэчлэх



үйл ажиллагаанаас эхлэх. Энэ нь хууль тогтоомжийн шинэчлэлийг хүлээлгүйгээр наана нь боллоцоотой бүх арга хэрэгслээр хууль сахиулагчдийг чадавхжуулж, иргэн төвтэй харилцааг бүрдүүлэх, ийм уур амьсгалд шилжих талаар нийгэм даяараа хийх компани ажил хэлбэртэй байж болно.

- Цагдаагийн алба, нэгж, газрууд дор дороо “суралцагч байгууллага” болж хөгжих;

- Албаны сургалтыг алба хаагчдын мэргэжлийн зэрэг, ажилласан жил, туршлагад тулгуурлан зохион байгуулах, Тухайлбал: 3, 5, 10, 15, 20 жил ажилласан алба хаагчдад зориулсан сургалтын ялгамжтай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

- Хууль сахиулагчдийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг онол гэхээсээ илүү мэргэжилтэн, шууд практик сургалтад суурилсан, шавь төвтэй сургалт нь хууль сахиулагчдийг бэлтгэхэд чиглүүлж өөрчлөх. Газар дээр нь заах, үзүүлэх, өөрсдөөр нь гардан дадлага хийлгэх арга хэлбэрүүд давамгайлсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

- Орон тооны бус сургагч багшийг сонгон шалгаруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах, урамшууллын механизм бий болгох.